



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/88


Улаанбаатар хот


Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/57 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, нийслэлийн Засаг даргын 2019 оны А/57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улаанбаатар хот, Датакарт консерциум хооронд байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилтэд хяналт тавьж, явцыг дүгнэх, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажиллах удирдамж, гэрээ дүгнэх үзүүлэлт, хуваарьт заасан ажил үүргийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/57 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүдээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажиллаж, гишүүдийг шаардлагатай мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр хангаж, уг ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд, гишүүдээр “Нууцын баталгаа” гаргуулах болон гэрээний явцыг дүгнэх ажиллагаанд оролцогч байгууллагуудад энэхүү тушаалыг хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/57 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргад тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2015 оны 04 сарын 01 өдрийн  
А/88 дугаар тушаалын хавсралт



## ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Б.Төгслхам

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн Ерөнхий мэргэжилтэн

Т.Хишигбэгз

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Батжаргал

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн

Д.Нансалмаа

Нийслэлийн Дотоод аудитын газрын Санхүүгийн аудитын хэлтсийн Ахлах аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч

Н.Батбилэг

Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын Системийн хөгжүүлэлтийн хэлтсийн дарга

Б.Батаа

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Энхтөр

Нийслэлийн нийтийн Тээврийн үйлчилгээний газрын Эрх зүйч

О.Анх-Эрдэнэ

Нийслэлийн нийтийн Тээврийн үйлчилгээний газрын Мэргэжилтэн